

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭСНИЙ
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТАЙЛАН**

2025 оны 06 дугаар сарын 04

Номгон

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Сүүрв түвшин	Зорилтот түвшин			Хүрсэн түвшин	Эхэлсэн Дууссан хугацаа	Биелэл тийн хувь
				Эхний хагас жилд	Сүүлчийн хагас жилд	7			
1	2	3	4	5	6	7	8	9	
<p>Зорилт 1. Захиргаа, хүний нөөц, дотоод ажил хариуцсан нэгжийн нэгтгэсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлага, албан хаагчдыг бодлогын зөвлөмжөөр хангах, төрийн байгууллагуудад арга зүйн туслалцаа дэмжлэг үзүүлэх</p>									
1.1	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнах ажлыг зохион байгуулах.	-Хэрэгжилтийн хувь	70	78	85	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2024 оны жилийн эцэс, 2025 оны 1 дүгээр сар, 1 дүгээр улирлын 183 тайланд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хяналт-хэрэгжүүлэх газарт 2025 оны 1 дүгээр сар, 1 дүгээр улирлын байдлаар 2 удаа тайлагнасан байна. Тайлангийн дундаж үнэлгээ 82.18 хувьтай байна.	2025.01.08 2025.04.11	100	
1.2	Монгол Улсын Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах ажлыг зохион байгуулах	-Хэрэгжилтийн хувь	89.41	91	95	Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар 89,41 хувьтай байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээний журам шинэчлэгдсэнтэй холбоотой Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг бүтэн жилийн тайланг цахим нээгээгүй. (2025 оны хэний хагас жилээр үнэлэх боломжгүй)	2025.02.10 2025.06.04	-	
1.3	Аймаг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд	-Хэрэгжилтийн хувь	87.05	90	90	Аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим системээр	2025.02.20 2025.03.10	100	

1	2	3	4	5	6	7	8	9
	хяналт шинжилгээ, үнэлгээ хийх					тайлагнасан 34 байгууллага нэгжийн тайлан болон нэгдсэн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүдийн дундаж үнэлгээ 80.27, агентлагуудын дундаж үнэлгээ 80.01 хувьтай байна. Аймгийн нэгдсэн тайланг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим системд 95.71 хувийн хэрэгжилттэй тайлагнасан.		
1.4	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хүлээн авч, үнэлэх	-Хэрэгжилтийн хувь	91.14	93	95	Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар сум, агентлаг, төрийн болон орон нутгийн өмчийн 54 байгууллагын хэмжээнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг аймгийн удирдах ажилтны зөвлөгөөнд танилцуулсан. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар 91.14% -тай байна.	2025.02.25 2025.03.10	100
1.5	Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.	-Хэрэгжилтийн хувь	79.43	80	85	Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний 387 үр дүн, үйл ажиллагаа, төсөл арга хэмжээнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж 87.5 хувиар үнэлэн Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний new.inelgee.gov.mn цахим системд бүртгэж, хэрэгжилтийг тайлагнасан. Аймгийн ИТХ-ын VII хуралдаанд хөгжлийн төлөвлөгөөний нийт 387 үр дүн, үйл ажиллагааны хэрэгжилтийг тайлагнаж, 87.5 хувьтай гэж дүгнэгдсэн.	2025.01.20 2025.04.03	100
1.6	Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний	-Хэрэгжилтийн хувь	78.2	82	90	Сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт Хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, аймгийн удирдах ажилтны зөвлөгөөнд танилцуулсан. Сумдын	2025.01.20 2025.03.20	100

1	2	3	4	5	6	7	8	9
	хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх					Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн дундаж 84.5% -тай байна.		
1.7	Хөгжлийн зорилтот болон дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	-Хэрэгжилтийн хувь	71	71	75	2024 оны жилийн эцэст хэрэгжилтийг тайлагнах 53 байгууллагаас хугацаандаа тайлагнасан-39, хугацаа хоцорч тайлагнасан-14, тайлагнаж 78.87 хувьтай дүгнэгдсэн. Нийт 9 дэд хөтөлбөрийн /155 заалт/ хэрэгжилт дундажаар 83,69 хувьтай хэрэгжсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4,16 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Үр дүнтэй буюу 100 хувийн үнэлгээтэй 1, Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-100 хувийн үнэлгээтэй 6, Эрчимжүүлэх шаардлагатай буюу 30-70 хувийн үнэлгээтэй 2 дэд хөтөлбөр байна.	2025.01.20 2025.02.20	100
1.8	Хуульд нийцүүлэн хүчингүй болсонд тооцсон болон хугацаа дууссан бодлогын баримт бичгийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	-Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн тоо	-	5	5	Хугацаа дуусгавар болсон дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэх тайлан ирүүлээгүй учир үнэлгээ хийгдээгүй.	2025.04.01 2025.05.30	0
1.9	Аймгийн Төлөөлөгчдийн Хурлын Иргэдийн Хурлын тогтоолын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	-Хэрэгжилтийн хувь	70	85	90	2024 оны жилийн эцэст 55 байгууллага аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 28 тогтоолын 41 заалтыг хяналтад авч ажилласан ба 51 байгууллага хугацаандаа тайлагнаж 4 байгууллага тайлан хоцроосон, тайлагнаагүй байгууллага байхгүй байна. Хяналтад байгаа 41 заалтын хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд бүрэн хэрэгжсэн буюу 100 хувийн хэрэгжилттэй 32, хэрэгжих шатанд буюу 70%-ийн хэрэгжилттэй 7, хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувийн хэрэгжилттэй 2, хэрэгжилтийн дундаж хувь 91,46 хувьтай хэрэгжсэн. Нэгдсэн тайланд хяналт шинжилгээ,	2025.01.20 2025.02.20	100

1	2	3	4	5	6	7	8	9
						<p>үнэлгээ хийхэд бүрэн хэрэгжсэн буюу 100%-ийн хэрэгжилттэй 32, хэрэгжих шатанд буюу 70 хувийн хэрэгжилттэй 7, хэрэгжилт хангалтгүй буюу 30%-ийн хэрэгжилттэй 2 заалтын хэрэгжилтийн үнэлгээг цахимд тайлагнан хүргүүлсэн. Хэрэгжилтийн дундаж хувь 91,46 хувьтай хэрэгжсэн. Нэгдсэн тайлан боловсруулж аймгийн ИТХ-ын ажлын албанд 2025.05.05-ны өдрийн 2/575 албан бичгээр хүргүүлсэн.</p>		
1.10	Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах ажлыг зохион байгуулах.	-Хэрэгжилтийн хувь	70	85	90	<p>2024 оны жилийн эцсийн байдлаар хяналтад байгаа 3173 заалтын хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд бүрэн хэрэгжсэн буюу 100%-ийн хэрэгжилттэй 2225, хэрэгжих шатанд буюу 70%-ийн хэрэгжилттэй 543, хэрэгжилт хангалтгүй буюу 30%-ийн хэрэгжилттэй 234, хэрэгжээгүй 136, хэрэгжилт тооцох хугацаа болоогүй 33 заалтын хэрэгжилт 95,6 хувьтай үнэлэгдсэн. Нэгдсэн тайлан боловсруулж 2025.05.05-ны өдрийн 2/576 албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>2025 оны I улиралд захирамж, албан даалгаврын хяналтад авсан 141 заалтад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд бүрэн хэрэгжсэн буюу 100 хувийн хэрэгжилттэй 27, хэрэгжих шатанд буюу 70 хувийн хэрэгжилттэй 25, хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувийн хэрэгжилттэй 10, хэрэгжээгүй буюу 0 хувийн хэрэгжилттэй 77, хугацаа болоогүй 2 заалтын хэрэгжилт 34.17 хувьтай үнэлэгдсэн. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 51.67 хувиар буурсан үзүүлэлттэй байна.</p>	2025.02.01 2025.03.01	100
1.11	Байгууллага, албан тушаалтнуудад Хяналт-	-Зөвлөмжийн тоо	5	3	6	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс, аймгийн Засаг даргын Тамгын	2025.02.25 2025.03.10	100

1	2	3	4	5	6	7	8	9
	шинжилгээ, үнэлгээний зөвлөмж өгч, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах					газрын хэлтэс, агентлагуудын 2023 оны болон 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүдийн дундаж хэрэгжилт 81.37 хувь, агентлагуудын зөвлөмжийн дундаж хэрэгжилт 84.80 хувьтай, сумдын дундаж хэрэгжилт 77.17 хувь, төрийн болон орон нутгийн өмчийн газруудын дундаж хэрэгжилт 86.84 хувьтай үнэлэгдсэн байна.		
Зорилт 2. Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэх, мэдээлж тайлагнах, арга зүйн зөвлөмжөөр хангах, чадавхжуулах, гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг сайжруулах								
2.1	Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хэрэгжилтийн тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	-Хэрэгжилтийн хувь	71	75	80	Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 онд орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 19 гэрээний 875 заалтын хэрэгжилтийг 31 байгууллага тайлагнахаас 30 байгууллага ирүүлж, гэрээний заалтыг 86.32 хувь, хавсралтын заалтыг 80.5хувьтай тайлагнасан. Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 онд орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 19 гэрээний 875 заалтын хэрэгжилтийг new.ipee.gov.mn цахим системд хугацаанд нь 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдөр тайлагнаж баталгаажуулсан. Аймгийн Засаг даргын Засгийн газрын гишүүдтэй байгуулсан 2025 оны 20 салбарын гэрээг pdf файлаар хүлээн авч word файл руу хөрвүүлэн 15 сайдын гэрээний 467 заалтыг new.ipee.gov.mn цахим системд байршуулсан.	2025.01.01 2025.05.10	100
2.2	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	-Хэрэгжилтийн хувь	80	75	90	Байгууллагын гүйцэтгэлийн тайланг Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын	2025.06.20 2025.12.20	-

1	2	3	4	5	6	7	8	9
						гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловруулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын дагуу 2025 оны 06 дугаар сарын 15-нд хүлээн авч хяналт-шинжилгээ хийгдэнэ.		
2.3	Аймгийн Засаг дарга сумдын Засаг дарга нарын хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	-Хэрэгжилтийн хувь	91	71	92	Аймгийн Засаг даргаас сумдын Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, сумдын үнэлгээнд оруулан тооцсон. Хэрэгжилтийн дундаж хувь 89.17 хувьтай байна.	2025.01.20 2025.03.10	100
2.4	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	-Хэрэгжилтийн хувь	78	80	85	Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллага, сумдын Засаг даргын Тамгын газар нийт 54 байгууллагад хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, 2024 оны жилийн эцсийн нэгдсэн дүнд оруулан тооцсон. Дундаж 82.5 хувийн хэрэгжилттэй байна.	2025.02.20 2025.03.10	100
2.5	Ил тод байдлын шалгуур үзүүлэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах ажлыг зохион байгуулах.	-Хэрэгжилтийн хувь	66	70	74	Аймгийн Засаг даргын Тамгын газрын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн тайланг 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний new.ipeegee.gov.mn цахим системд 100 хувийн хэрэгжилттэй тайлагнасан. Нутаг дэвсгэрийн ил тод байдлын үнэлгээг аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний системд бүртгэлтэй 20 сум, Засаг даргын харьяа 24 агентлаг, төрийн болон орон нутгийн өмчийн 10 байгууллага, нийт 54 мэдээлэл хариуцагчийн тайланд хяналт-шинжилгээ хийхэд дундаж үнэлгээ 74.49 хувь байсан бөгөөд үнэлгээг Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж	2025.01.05 2025.02.01	100

1	2	3	4	5	6	7	8	9
2.6	Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх	-Хэрэгжилтийн хувь	73	75	80	<p>гаргах орон тооны бус зөвлөлд 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 1а/67 тоот албан бичгээр хургуулсан.</p> <p>-Баянхонгор аймаг нь 2024 онд 300,000 ширхэг модыг тарьж, ургалтын хувийг 70%-д хүргэх зорилт тавьсан бөгөөд 147,148 ширхэг мод, бут, сөөгийг тарьж, ургалтын хувийг 77%-д хүргэсэн байна. Хяналт шинжилгээ, үнэлгээгээр Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой "Тэрбум мод" төсөл, арга хэмжээний 2024 оны хэрэгжилтийг 90% буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэв.</p> <p>-Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 02 дугаар албан даалгавар, аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар албан даалгавар, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 131 дүгээр тогтоолоор батлагдсан "Хог хаягдлын менежментийг сайжруулах аймгийн хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.</p> <p>Хяналт шинжилгээ, үнэлгээгээр Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой "Хог хаягдал" төсөл, арга хэмжээний 2024 оны хэрэгжилтийг 100% буюу "Үр дүнтэй" гэж дүгнэв.</p> <p>-Баянхонгор аймаг нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах, иргэдийн тоон бичиг үсгийн чадавхыг нэмэгдүүлэх, төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааг 2024 онд цахимжуулахад анхаарч ажилласан ба хэрэгжилтийг 90%-тай хэрэгжүүлж ажилласан байна. Хяналт шинжилгээ, үнэлгээгээр Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой "Цахим" төсөл, арга хэмжээний 2023</p>	2025.01.31 2025.03.01	100

1	2	3	4	5	6	7	8	9
						оны хэрэгжилтийг 90% буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэв. Нэгдсэн тайлан, илтгэх хуудсыг хугацаанд нь хургуулж ажилласан.		
2.7	Агентлаг, орон нутгийн өмчийн байгууллагын тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	-Хэрэгжилтийн хувь	85	85	85	Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төрийн болон орон нутгийн өмчийн 35 байгууллагын 164 тэрүүлэх ач холбогдолтой шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, 2024 оны жилийн эцсийн үнэлгээнд оруулан тооцсон.	2025.02.31 2025.03.10	100
2.8	Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд хяналт тавих	-Хэрэгжилтийн хувь	78	80	80	Аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний системээр сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн тайланг 2024 оны жилийн эцсийн байдлаар хүлээн авсан. Цахим системээр тайлан ирүүлсэн 12 сумын тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.	2025.01.17 2025.01.25	60
2.9	Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх.	-Хэрэгжилтийн хувь	78	80	90	Аймгийн хэмжээнд 2024 онд: 1."Тэгш хүртээмжтэй цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь", 2."Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох", 3."Эх хүүхдийн эрүүл мэндийн хөтөлбөр", 4."Сэргийлж болох эх нярайн эндэгдлийг бууруулах нь", 5."Хамтарсан багийн гишүүдийн айл өрхөд үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэх, тараах 6-10 насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд зориулсан мэдээллийн багц боловсруулах", 6."Хамгаалах байр тохижуулах", 7."Монгол унагаг байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь /Epsure/", 8."Бага насны хүүхдийн цогц хөгжилд	2025.01.20 2025.03.01	100

1	2	3	4	5	6	7	8	9	
						<p>эцэг эхийн оролцоот нэмэгдүүлэх нь", 9. "GOATS буюу ЯМАА", 10. "WIFI буюу Махны нэмүү өртгийн сүлжээ" зэрэг төсөл, хөтөлбөрүүд хэрэгжсэн, хэрэгжилтийн дундаж 98 хувьтай байна.</p> <p>Хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж нэгдсэн тайланг Засгийн Газрын хяналт хэрэгжүүлэх газарт 2025.03.07-ны өдрийн 1а/170 албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж нэгдсэн тайланг Засгийн Газрын хяналт хэрэгжүүлэх газарт 2025.03.07-ны өдрийн 1а/170 албан бичгээр хүргүүлсэн.</p>			
2.10	Улс, аймаг, салбарын хэмжээнд гаргасан онцгой амжилт, шинэлэг санал, санаачилга гарган амжилттай хэрэгжүүлсэн, нийгэм, эдийн засаг болон орон нутгийн хөгжилд гарсан өөрчлөлт, гаргасан ажлын үр дүн болон тухайн жилд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтийг үнэлж, Удирдлагын багт танилцуулах	-Хэрэгжилтийн хувь	-	80	90	Олон улсын 9001:2015 чанарын менежментийн тогтолцоо-шаардлага стандартыг хэрэгжүүлсэн Өлзийт, Баянхонгор сумдад үнэлгээг тооцож, удирдлагын багт танилцуулан 10 оноо өгсөн.	2025.02.30 2025.03.10	100	
2.11	Аймгийн Хяналт шинжилгээ, үнэлгээний 2024 оны тайлан, Агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газар, Төрийн болон орон нутгийн өмчийн болон төсөвт байгууллагууд, аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний нэгдсэн тайланг гарган байгууллагуудад хүргүүлэх	Тайлангийн тоо	60	60	60	Баянхонгор аймгийн 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн газрын Засгийн Тамгын газарт, агентлагуудын 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг 24 агентлагт, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудын 2024 оны үйл	2025.03.01 2025.03.28	62	

1	2	3	4	5	6	7	8	9
						ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг 11 байгууллагад, нийт 37 байгууллагад нэгдсэн тайлан хургуулсан.		
2.12	Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Тайлангийн тоо	1	1	1	Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн гүйцэтгэлийг гарган Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хургуулсан.	2025.03.01	100
2.13	Сургалтын хэрэгцээний судалгаа авч, хөгжлийн бодлого, төлөвлөлт, гүйцэтгэлийн үр дүнг сайжруулах сургалт зохион байгуулах	Хамрагдсан хүний тоо	200	300	400	"Бодлого, төлөвлөлт, гүйцэтгэл" сэдвээр Заг сумын "Төрийн албан хаагчдын зөвлөгөөн" болон "Боловсролын салбарын удирдах албан хаагчдын зөвлөгөөн"-д 2 удаа, нийт 134 хүнд сургалт хийсэн. Сум, агентлагуудаас 2025 оны 5 дугаар сард сургалтын хэрэгцээний судалгааг авахад 14 сум, 18 агентлаг, 5 төрийн болон орон нутгийн өмчийн байгууллага, нэр тодорхойгүй 5, нийт 42 байгууллагаас 24 төрлийн сургалт, мэдээллийг аймгийн Засаг даргын Тамгын газраас авах санал ирсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс журам, тайлан бичих арга зүйн сургалтыг Жинст, Шинэжинст сумд, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, Мал эмнэлгийн газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар зэрэг 2 сум, 4 агентлаг сургалт авах захиалга ирүүлсэн. Сургалтыг 6 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөгөөнд тусгав.	2025.02.14 2025.05.27	100
Зорилт 3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний бодит мэдээ, мэдээллээр удирдлага болон хэрэглэгчийг хангах								
3.1	Сум, агентлагууд, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудад хяналт шинжилгээ, үнэлгээ хийх,	-Хамрагдсан байгууллагын тоо	54	54	54	Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 03 дугаар удирдамжийн дагуу 20 сумыг 4 чиглэл /баг/, 24	2025.01.27 2025.02.21	100

1	2	3	4	5	6	7	8	9
	зөвлөн туслах ажлыг тогтмолжуулж, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн үр дүнг дээшлүүлэх					агентлаг, 11 төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагыг 6 чиглэл /баг/, нийт 55 байгууллагын 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж бодлогын зөвлөгөө, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах ажлыг 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс 02 дугаар сарын 21-ний өдрүүдэд зохион байгуулсан.		
3.2	Багийн Засаг даргын нарын ажлыг үнэлэх ажлыг зохион байгуулах	Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдсан багийн Засаг даргын тоо	-	100	100	Багийн Засаг дарга нарыг үнэлэх шалгуур үзүүлэлтийг боловсруулан хагас жилээр батлуулна.	2025.05.01 2025.06.15	-
3.3	Төрийн байгууллагуудын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим систем bayankhongor.igovernment.mn цахим сангийн хөгжүүлэлт хийх	-Гэрээний гүйцэтгэлийн хувь	-	50	100	Аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим системд хөгжүүлэлт хийх ажил Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Хяналт-шинжилгээ хийх журам", "Үнэлгээ хийх журам", "Байгууллагын үйл ажиллагааг үнэлж дүгнэх журам"-ыг хэрэгжүүлэх аргачлал, төсвийн асуудал шийдэгдээгүйгээс хүлээгдэж байна.	2025.03.02 2025.06.04	0
3.4	Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, орон нутгийн өмчийн болон босоо удирдлагатай төсөвт байгуулага, сумдын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг ард иргэдэд нээлттэй сурталчлах	-Олон нийтэд нээлттэй мэдээлсэн мэдээний тоо	1	1	2	Хэлтсийн үйл ажиллагааны ил тод байдлыг ханган хэлтсийн самбарын мэдээллийг шинэчилэн Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн, бусад мэдээллийг байршууллаа. Мөн холбогдох журмуудыг QR коджуулан байршуулсан.	2025.04.20 2025.05.20	100




1	2	3	4	5	6	7	8	9
Зорилт 4. Хэлтсийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэргэшил арга зүйн удирдлагаар хангах болон хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх								
4.1	Хэлтсийн болон төрийн албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулах, үр дүнг үнэлэх	Төлөвлөгөө, тайлангийн тоо	4	4	4	Хэлтсийн болон төрийн албан хаагчдын 4 гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, 1 дүгээр улирал, эхний хагас жилийн байдлаар үр дүнг тооцон ажиллаж байна.	2025.01.10 2025.06.05	100
4.2	Хэлтсийн 2025 оны баримтыг байгууллагын архивт өгөх	Архивт өгсөн баримтын тоо	29	30	30	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хэлтсийн 2 албан хаагч 2024 оны 22 нэр төрлийн баримтыг эмхлэн цэгцэлж, архивт хүлээлгэн өгсөн.	2025.04.07	67
4.3	Хэлтсийн дотоод бичиг баримтыг албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцүүлэн зохион бүрдүүлэх	Баримт бичгийн төрөл	3	3	3	Хэлтсийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. Ирсэн бичгийн бүртгэлийг хөтөлж, журмын дагуу зохион байгуулалтыг хийж байна. Хэлтсийн хурал 1 удаа хийж тэмдэглэл хөтөлж баримтжуулсан.	2025.01.02 2025.06.04	100
4.4	9001:2015 менежментийн шаардлага хэрэгжүүлэх чанарын тогтолцоо-стандартыг	Үл тохирлын тоо	-	-	-	Тус хэлтсээс стандартыг хэрэгжилтийг зохион байгуулах Чанарын багт 1, Бүтээмжийн багт 1, Дотоод аудитын багт 3 албан хаагч ажиллаж, стандартын холбогдох шаардлагыг хэрэгжүүлэн, хяналт тавьж ажиллаж байна. Тайлант хугацаанд үл тохирол гараагүй.	2025.01.02 2025.06.04	100
4.5	Орон нутгийн хөгжил, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах шинэлэг ажил, арга хэмжээг зохион байгуулах	Шинэлэг ажлын тоо	-	1	3	Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 03 дугаар удирдамж, мөн 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 40 дүгээр удирдамжуудаар сум байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр 2 удаагийн ажил зохион байгуулсан.	2025.01.16 2025.06.05	100
4.6	Албан хаагчдын мэдлэг, ур чадвараа тасралтгүй хөгжих боломж, нөхцөлийг бүрдүүлэх	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	-	1	4	"Төрийн албан хаагчийн сургалтын тогтолцоог сайжруулах" ажлын хүрээнд: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас зохион байгуулсан "Монгол Улсын хөгжлийн бодлогын үнэлгээний	2025.01.02 2025.06.04	100

1	2	3	4	5	6	7	8	9
						<p>чадавхын индекс тогтоох, ХШҮ хийх, байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх арга зүй” сургалтад 2 албан хаагч</p> <p>Төрийн байгууллагад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх сургалтад 2 албан хаагч</p> <p>Стандарт хэмжил зүйн газраас зохион байгуулсан “MNS ISO 9001:2016 Чанарын удирдлагын тогтолцоо-шаардлага”, “MNS ISO 19011:2020 Менежментийн тогтолцоонд аудит явуулах арга зүй” сургалтад 1 албан хаагч тус тус хамрагдсан.</p>		

ТАНИЛЦСАН:
 АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
 ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
 Т.ХИШИГБААТАР

ХЯНАСАН:
 ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛЭЭНИЙ ХЭЛТЭГИЙН
 ДАРГА
 Т.ЭРДЭНЭБАТ

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:
 НИЙГМИЙН БОДЛОГЫН САЛБАРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ,
 ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
 Б.БУЛГАМАА



**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА Т.ЭРДЭНЭБАТЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ
ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар

Нэгжийн нэр: Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт (70 оноо)
1	2	3	4
1.	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	89,9.	62,3.

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Арга хэмжээ 1. Холбогдох хууль тогтоомжийг уншиж судална	100	15
2.	Арга хэмжээ 2. Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээнд чиглэсэн сургалтад хамрагдах	50	4,5.
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо			11,25.

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хандлага, ёс зүй	15
2.	Удирдан зохион байгуулах	15
3.	Асуудал шийдвэрлэх	15
4.	Манлайлах	15
5.	Багаар ажиллах	15
6.	Харилцаа	15
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
7.	Мэргэжлийн ур чадвар 1. Удирдан зохион байгуулах	
8.	Мэргэжлийн ур чадвар 2. Дүн шинжилгээ хийх	
9.	Мэргэжлийн ур чадвар 3. Асуудал шийдвэрлэх	
10.	Мэргэжлийн ур чадвар 4. Манлайлах	
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		15

4. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)	62,3
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	11,25
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	15
4.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо		88,55.

ҮНЭЛГЭЭ ӨГСӨН:
 АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
 ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
 ГҮЙЦЭТГЭГЧ Т.ХИШИГБААТАР

..... (огноо)

ҮНЭЛГЭЭТЭЙ ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:
 ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
 ХЭЛТСИЙН ДАРГА Т.ЭРДЭНЭБАТ

2025.06.18 (огноо)

0324020016
 ТУ34247 9007342